



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 27/060

Арвайхээр

**Газар ашиглалтын зориулалтад
өөрчлөлт оруулах тухай**

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3.4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Б.Амгаланбаатар (ЙЮ88011274)-ын гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын 13 дугаар баг Төв 1 дүгээр гудамж 109 тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 400 м² газрын зориулалтыг үйлчилгээний зориулалттай болгон өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101245